**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН**
**ТУШААЛ**

2025 оны 07 сарын 08 өдөр Дугаар А/49 Улаанбаатар хот

Байгууллагын тусламж, үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалыг, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойн баярын өдрүүдэд зоонозын халдварт өвчин, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах дуудлагад үйлчлэх баг, хариуцлагатай жижүүр, шаардлагатай үед дуудагдан ажиллах албан тушаалтнууд болон хяналт тавих албан тушаалтны нэрс, зоонозын халдварт өвчний дэгдэлт, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд нэмэлтээр ажиллах багийг тус тус хавсралтаар баталсугай.

2. Тухайн амралтын өдрүүдэд халдварт өвчний дуудлагын багийн бэлэн байдал, хариу арга хэмжээг тухай бүр зохион байгуулан, байгууллагын цахилгаан, дулаан, гадна орчны аюулгүй байдалд хяналт тавьж, өглөө бүрийн 08 цагаас өмнө тухайн өдрийн мэдээллийг хавсралт хүснэгтийн дагуу бэлтгэж, Биостатистикчаар хянуулан, өдөр бүрийн 09:00 цагт Төвийн удирдлагад утсаар мэдээлэх болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.ds.hdc.gov.mn цахим хаяг, Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллахыг дуудлага хяналтын бага эмч, томилогдсон хариуцлагатай жижүүр, биостатистикч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой, яаралтай шийдвэрлүүлэх асуудал, зоонозын халдварт өвчин, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед төвийн захирал болон холбогдох албаны дарга нарт шуурхай мэдээлж, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг сарын дуудлагын баг, дуудлага хяналтын бага эмч нар, Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Яаралтай дуудлагын үед шаардагдах багаж, тоног төхөөрөмж, оношлуур урвалж, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, шатахуун, тослох материал, цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах, гал түймэр аваар ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, яаралтай үед обьектоос гаргах бараа материал, эд зүйлсийн зөвшөөрөл олгох, дуудлагад үйлчлэх автомашинуудын бэлэн байдлыг хангаж, ажиллахыг Санхүү хангамж, нөөцийн албаны дарга (Д.Болдбаатар)-д, Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг) нарт тус тус хариуцуулсугай.

5. Эрүүл мэндийн яамнаас гаргасан холбогдох тушаал, шийдвэр болон энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулах, нийт ажилтан албан хаагчдад танилцуулах, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж, 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт хүргүүлэхийг Хүний нөөцийн менежер (Э.Пагмадулам)-т даалгасугай.

6. Байгууллагын өрөө тус бүрийн хаалгыг лацдаж, түлхүүрийг бага эмчид хүлээлгэн өгөх, уг амралтын өдрүүдэд гар утсаа нээлттэй байлгах, үүрэг гүйцэтгэж буй ажилтан ажлын байрыг орхиж явах, согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчил гаргахгүйгээр сахилга, хариуцлагатай байхад онцгой анхаарах, шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах шаардлага үүссэн үед байгууллагаас мэдээлэл өгснөөс хойш 1 цагийн дотор, ээлжийн амралт эдэлж буй тохиолдолд 24 цагийн дотор ажлын байранд цуглан баярын амралтыг үл харгалзан үүрэг чиглэлийн дагуу ажиллахыг нийт ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

7. Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах цахим хаяг (**Зоонозын өвчин судлалын үндэсний төв**) дуудлага хүлээн авах 70282853 дугаарын утсыг байнгын нээлттэй байлгахыг дуудлага хяналтын бага эмч нар болон хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АМГАЛАНБАЯР

ТТ35150 9092005

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны ..07.. дугаар сарын ..08...-ны өдрийн
А/149... дугаар тушаалын хавсралт

## БАЯР АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Албан тушаал | Нэрс | Утасны дугаар | ТАЙЛБАР |
|---|---|---|---|---|
| | | **Дуудлагад үйлчлэх баг** | | |
| 1. | Халдвар судлаач | Ч.Бат-Ирээдүй | 89960686 | |
| 2. | Эмнэл зүйч эмч | Ч.Буянхишиг | 88960698 | |
| 3. | Генетикч | Я.Сарнай | 89980864 | |
| 4. | Нян судлаач | Б.Алтантуяа | 89658690 | |
| 5. | Лаборант | Т.Мөнхтуяа | 95966916 | |
| 6. | Амьтан судлаач | С.Мөнгөнбагана | 88069184 | |
| 7. | Ариутгагч | Н.Равжир | 99263130 | |
| 8. | Биобэлдмэлчин | Ц.Мөнхсүрэн | 80801738 | |
| 9. | Түргэн тусламжийн жолооч | Ч.Лхагвасүрэн | 99753973<br>89893973 | |
| | | **Бага эмч** | | |
| 1. | Бага эмч | Э.Алтанзул | 99980449 | 7 дугаарс сарын 10 |
| 2. | | Я.Мөнхтөр | 99217139 | 7 дугаар сарын 11 |
| 3. | | Я.Ягаанхүү | 99217139 | 7 дугаар сарын 12 |
| 4. | | Э.Алтанзул | 99980449 | 7 дугаар сарын 13 |
| 5. | | Я.Мөнхтөр | 99217139 | 7 дугаар сарын 14 |
| 6. | | Я.Ягаанхүү | 99217139 | 7 дугаар сарын 15 |
| 7. | | Э.Алтанзул | 99980449 | 7 дугаар сарын 16 |
| 8. | | Я.Мөнхтөр | 99217139 | 7 дугаар сарын 17 |
| 9. | | Я.Ягаанхүү | 99217139 | 7 дугаар сарын 18 |
| 10. | | Э.Алтанзул | 99980449 | 7 дугаар сарын 19 |
| 11. | | Я.Мөнхтөр | 99217139 | 7 дугаар сарын 20 |
| | | **Хариуцлагатай жижүүр** | | |
| 1. | Албаны дарга | Б.Ичинхорол | | 7 дугаар сарын 10 |
| 2. | Албаны дарга | У.Өнөрсайхан | | 7 дугаар сарын 11 |
| 3. | Албаны дарга | Х.Ариунболд | | 7 дугаар сарын 12 |
| 4. | Албаны дарга | Д.Алтантогтох | | 7 дугаар сарын 13 |
| 5. | Хүний нөөцийн менежер | Э.Пагмадулам | | 7 дугаар сарын 14 |
| 6. | Эдийн засагч | Б.Номин-Эрдэнэ | | 7 дугаар сарын 15 |
| 7. | Халдвар судлаач | Г.Зулцэцэг | | 7 дугаар сарын 16 |
| 8. | Албаны дарга | У.Өнөрсайхан | | 7 дугаар сарын 17 |
| 9. | Албаны дарга | Х.Ариунболд | | 7 дугаар сарын 18 |
| 10. | Албаны дарга | Д.Алтантогтох | | 7 дугаар сарын 19 |
| 11. | Чанарын менежер | Э.Очиржамаа | | 7 дугаар сарын 20 |

| | | |
|---|---|---|
| 12. | Хангамж үйлчилгээ хариуцсан менежер О.Сансар-89104700 | Байгууллагын аюулгүй байдлыг хангах, гэнэтийн гамшиг, осол, тог цахилгаан, ус дулааны эрсдэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулах ажлыг яаралтай зохион байгуулах. Гар утсыг байнга нээлттэй байлгаж, дуудлага авах бэлэн байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд хэрэглэх багаж хэрэгслийн нөөцийг бэлтгэх. |
| **70282853 дугаартай утсаар 24 цагийн турш иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгнө.** | | |
| Хариуцлагатай жижүүрүүд Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам”-д заасан мэдээний урсгалын дагуу өдөр бүрийн 09:00 цагт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.ds.hdc.gov.mn цахим хаягаар байгууллагын цаг үеийн мэдээллийг хүргүүлнэ. | | |

Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд нэмэлтээр ажиллах баг

| № | Албан тушаал | Нэрс | Утасны дугаар | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Халдвар судлаач | А.Бямбахишиг | 80571900 | |
| 2 | Эмнэл зүйч эмч | Ч.Буянхишиг | 88960698 | |
| 3 | Генетикч | Н.Даваажав | 80013700 | |
| 4 | Нян судлаач | О.Эрдэнэцэцэг | 89128997 | |
| 5 | Лаборант | Ч.Буянхишиг | 88500619 | |
| 6 | Биологич | С.Отгонжаргал | 88000686 | |
| 7 | Ариутгагч | Б.Саранчимэг | 99781511 | |
| 8 | Биобэлдмэлчин | Б.Отгонбулаг | 88133908 | |
| 9 | Түргэн тусламжийн жолооч | Б.Пүрэв-Очир | 99147579 | |

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ